



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/125

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын засвар”-ын ажлын төсөв боловсруулах ажил “ДУОНӨГ/2017/00019/04”-ийн гүйцэтгэгчээр “Зам, барилга консолид консалтинг групп ХХК”-ийг сонгон 1,350,000 /нэг сая гурван зуун тавин мянга/ төгрөгөөр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Зураг төсвийн ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Зам, барилга консолид консалтинг групп” ХХК –ний захирал /Д.Доржсүрэн/-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, зураг төсвийн ажилд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Замын цагдаагийн тасгийн /Б.Цэндзэсэм/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0300383